

Хүлээгдлийн мэдээ

Кабинет	Үзүүлэх боломжтой хугацаа	Хүлээгдэл – ажлын хоногоор
Мэс засал	2016.03.16	
Урологи	2016.03.22	4
Бүдүүн шулуун гэдэсний мэс засал	2016.03.16	
Мэдрэл	2016.03.21	3
Үе судлал	2016.03.17	1
Мэдээгүйжүүлэг	2016.03.16	





МЭДЭЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс

Мэдээллийн ил тод байдал гэж юу вэ ?

Төр өөрийн явуулж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг иргэн, хуулийн этгээд болон сонирхогч бүлгүүдэд хуульд заасны дагуу нээлттэй байршуулж, мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангасан байх.



БИДНИЙ ҮҮРЭГ



**Иргэн, хуулийн
этгээдийн мэдээлэл
авахаар
гаргасан хүсэлтэд
бүрэн дүүрэн хариулт
өгөх**

**Хууль тогтоомжийн хүрээнд байгууллагын
нийтэд ил тод байх ёстой
мэдээллийг цаг тухайд нь түгээх**

Эрх зүйн орчин

- ▶ **Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоол /ИЛ ТОД БАЙДЛЫГ ИЛТГЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ БАТЛАХ ТУХАЙ/**
- ▶ **Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль /2011 он/**
- ▶ **Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоол /МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ НИЙТЛЭГ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ/**
- ▶ **Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 212 дугаар тогтоол /ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САНГ АШИГЛАХ ЖУРАМ/**
- ▶ **Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоол /ТӨРӨӨС МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ХӨГЖЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО БАТЛАХ ТУХАЙ/**
- ▶ **Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоол /ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨХ НИЙТЛЭГ ЖУРАМ/**
- ▶ **Шилэн дансны тухай хууль /2014/**
- ▶ **Авлигын эсрэг хууль /2006/**

ШВЕД УЛС:

Шведийн Засгийн газар үйл ажиллагаандаа ил тод байдлыг нэвтрүүлснээр авлигын хэрэг бараг гарахгүй болсон байна. Шведэд Засгийн газрын ажилтнууд ажил үүргийнхээ талаар аливаа мэдээлэл, томилолтынхоо зардлын зориулалтыг хүртэл жижиг гэхгүйгээр үйл ажиллагааныхаа тайланд дэлгэрэнгүй тусгаж, ил тод мэдээлэх үүрэгтэй байдаг.



ТӨРИЙН БАЙГУУЛЛАГААС ИРГЭДЭД ЗОРИУЛАН
ТҮГЭЭЖ БУЙ МЭДЭЭЛЭЛ ЯМАР БАЙХ ЁСТОЙ ВЭ?

Ямарч хүн уншаад ойлгогдохоор энгийн

Үйлчлүүлэгчдийн эрэлт, хэрэгцээнд
тулгуурласан

Мэргэжлийн хүнд нэр томъёо, үг хэллэг байхгүй

ИРГЭН ЯМАР МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХТЭЙ ВЭ?

Төрийн байгууллагын
үйл ажиллагаатай
холбоотой мэдээлэл



Төрийн болон орон
нутгийн өмчийн
хөрөнгөөр бараа, ажил,
үйлчилгээ худалдан авах
ажиллагааны талаархи
мэдээлэл

Төрийн албан хаагчийн
хувийн ашиг сонирхол
хөрөнгө, орлогын
мэдээлэл

Төрийн
байгууллагын хүний
нөөцтэй холбоотой
мэдээлэл

Төрийн байгууллагын
төсөв санхүүтэй
холбоотой мэдээлэл

ИРГЭД ЯМАР МЭДЭЭЛЛИЙГ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГААС АВАХЫГ ХОРИГЛОДОГ ВЭ?

- Төрийн нууц

- Байгууллагын нууц

- Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцын талаарх мэдээлэл



- Хувь хүний нууц

- Хяналт шалгалт явуулах үүрэг бүхий байгууллагад шалгагдаж байгаа асуудалтай холбоотой мэдээлэл

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ НИЙТЛЭГ ҮҮРЭГ

- Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдал /тушаал, захирамж/
- Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, заавар
- Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсан-даа байршуулсан байх, төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг хүлээн авах боломжийг бүрдүүлсэн байдал
- Сул орон тооны зар /тухай бүр шинэчилсэн/
- Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам
- Жилийн төсөв, жилийн эцсийн санхүүгийн тайлан
- Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/
- Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийн үнэ, тарифийн талаарх мэдээллийг хууль эрх зүйн үндэслэл журмын хамт байршуулах

МЭДЭЭЛЭЛ САЙТАЙ ИРГЭД ТӨРД ЯМАР АЧ ТУСТАЙ ВЭ?

- ✓ АЛБАН ТУШААЛТНУУД АВЛИГЫН ГЭМТ ХЭРЭГ
ҮЙЛДЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛНЭ
- ✓ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ЗОРИУЛАГДСАН ЗҮЙЛДЭЭ
ЗАРЦУУЛАГДАЖ ЭХЭЛНЭ
- ✓ ТӨР ТҮҮНИЙ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ИЛ ТОД
БАЙЖ ИРГЭД ИЛҮҮ МЭДЭЭЛЭЛТЭЙ БОЛНО
- ✓ ТӨР ИРГЭДИЙНХЭЭ ХҮСЭЛ ЗОРИЛГЫН ТАЛААР ИЛҮҮ
МЭДЭЭЛЭЛТЭЙ БОЛНО
- ✓ ТӨР ИРГЭД БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДАЙ ҮР
ДҮНТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ БОЛОМЖТОЙ БОЛНО
- ✓ ТӨР ОЛОН НИЙТТЭЙ ЗӨВШИЛЦӨХ БОЛОМЖТОЙ
БОЛСНООР АМЬДРАЛД НИЙЦЭХҮЙЦ ЗӨВ ШИЙДВЭР
ГАРГАНА
- ✓ ИРГЭД ТӨРИЙН ЗӨВ БОДЛОГЫГ ҮР ДҮНТЭЙ ДЭМЖИНЭ



МОНГОЛ УЛСЫН
АВЛИГАТАЙ
ТЭМЦЭХ ГАЗАР

*Зөв сонголт
Зөв үрээдүйг
бүтээгнэ*

1.000.000.000

8:09 AM

ХЭЗЭЭ Ч ҮГҮЙ!!!!

8:10 AM

Delivered



Message

Send

Авлигын эсрэг хуулийн 8.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй.



“Амьд хүний гэрч болсноос үхсэн хүний дэр бол”

“Адгийн зарга арав хоног”

“Төрийн төлөө огтоно боож үхнэ”

“Хар хүний өмнөөс шар хүн”

“Ноёнттой заргалдвал толгойгүй, нохойтой арсалдвал хормойгүй”

“Гүндүүгүй сайхан монгол эр хүн”, “Ичимхий даруу монгол бүсгүй”

МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АШИГЛАХ ВЭ?

Төрийн үйл
ажиллагаанд
үнэлгээ өгч
хяналт тавих

Үзэл бодол
саналаа
чөлөөтэй
илэрхийлэхдээ

Төрийн
үйлчилгээг
сайжруулахдаа
оролцохдоо

Төрийн
үйлчилгээг
түргэн,
шуурхай, тэгш
хүртээхдээ

ИРГЭД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВЧ БОЛОХ ВЭ?

Албан
ёсоор

- Тухайн байгууллагын бүх албан тушаалтанд хандах;
- Төрийн албан хаагчдаас шууд асуух;
- Төрийн байгууллагын цахим хуудсанд хандах;
- Төрийн байгууллагын дотор байрлуулсан мэдээллийн самбар;
- Нэг цэгийн үйлчилгээний ажилтнуудаас тодруулах;
- Төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтанд мэдээлэл авахаар бичгээр хандах;

Албан
бусаар

- Төрийн байгууллагын удирдах буюу тухайн ажил хариуцсан хүний хэвлэл мэдээллийн хэрэгслээр ярьсан яриа;
- Дам байдлаар бусдын ам дамжсан яриа;

ЯМАР ХУГАЦААНД МЭДЭЭЛЛИЙГ ИРГЭНД ГАРГАЖ ӨГӨХ ЁСТОЙ ВЭ ?

Мэдээллийг авах хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд **7** өдрийн дотор өгөх бөгөөд хүсэлтийг иргэд хамтран гаргасан бол тэдгээрийн төлөөлөл болох нэг иргэнд мэдээллийг өгнө.



МЭДЭЭЛЭЛ АВЧ, АШИГЛАХ НЬ ЯМАР АЧ ХОЛБОГДОЛТОЙ ВЭ?

Төрийн
үйлчилгээ
ний чанар
хүртээмж
дээшилнэ

Төр иргэдээ
сонсдог
болно

Төрийн
байгууллага,
албан
тушаалтан
хариуцлагатай
болно

Иргэдийн
төрд итгэх
итгэл
дээшилнэ

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА ИЛ ТОД БАЙДЛАА ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ЯМАР АРГА ХЭМЖЭЭ АВАХ ҮҮРЭГТЭЙ ВЭ?



Цахим хуудаст байршуулах



Мэдээллийн самбарт байршуулах



Иргэдийг хүлээн авч мэдээлэл өгөх



Бусад арга хэлбэр



ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙХ ТАЛААР...

Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх чиг үүрэг бүхий байгууллага өөрийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм, журмаа үйлчлүүлэгчдэд харагдахаар газарт байрлуулах;

Иргэд, хуулийн этгээдэд төрөөс үзүүлэх үйлчилгээг хүргэдэг төрийн албан тушаалтны чиг үүрэг, эрх хэмжээ, ямар үйлчилгээг ямар хугацаанд үзүүлэх, бүрдүүлэх шаардлагатай материал зэргийг агуулсан танилцуулгыг үйлчлүүлэгчдэд тараах, эсхүл тэдэнд харагдахаар газарт бичиж тавих;

Иргэдийг хүлээн авч уулзах, цагийн хуваарь, уулзах ажилтны овог нэр, харилцах утсыг тодорхой бичиж, байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн самбарт болон вэб сайтад байрлуулах;

Мэдээллийг вэб сайтаар түгээхийн зэрэгцээ хэвлэмэл материал, тодорхой зөвлөгөө бүхий гарын авлага, зурагт хуудас гарган тараах;

Иргэдийг хүссэн мэдээллээ авч чадахгүй байгаа талаар гомдол, санал ирүүлсэн тохиолдолд холбогдох арга хэмжээ авах, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох механизмыг бий болгох;

Иргэд, хуулийн этгээдэд хэрэгцээтэй тэдэнд хамаарах шийдвэрээ нийтэд вэб сайт болон бусад хэлбэрээр мэдээлж байх;

Төрийн үйлчилгээний бүх төрлийн төлбөр, хураамжийг бодитой тогтоох, үндэслэлгүйгээр илүү болон нэмэгдэл төлбөр, хураамж авах асуудлыг таслан зогсоох;

Байгууллагын удирдлагын шийдвэртэй холбогдох материал, төсвийн зарцуулалт, албан хаагчийн мэдээллийг байгууллага бүр дотооддоо ил тод, нээлттэй болгох;

Иргэдийн хэрэгцээт мэдээллийг вэб сайтдаа тавих, тавьсан мэдээллээ байнга шинэчилж байх;



ҮЙЛ АЖИЛЛАГААНД ИРГЭДИЙН ОРОЛЦОХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЭХ ТАЛААР...

Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн байгууллагад иргэд чөлөөтэй нэвтрэх боломжийг бүрдүүлэх;

Иргэдээс мэдээлэл хүлээн авах утас ажиллуулах, эсхүл санал хүсэлтийн хайрцагыг байгууллагад байрлуулан иргэдийн санал, хүсэлтийг авч, түүний мөрөөр холбогдох арга хэмжээ авч ажиллах;

Төрийн байгууллага тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн санал бодлыг авч, анхаарал татаж байгаа мэдээллийг нээлттэй болгох;


Тухайн байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол олон нийтэд ил тод байлгаж, тэдгээртэй танилцах боломжоор хангах;

ХУУЛЬ ЗӨРЧИГЧДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Түүнийг томилсон эрх бүхий этгээд Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна.

Иргэн хуулийн этгээдийн мэдээлэл авах эрхийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн албан хаагчийг эрх бүхий этгээд Төрийн албаны тухай хуулийн 25.1.1-д заасан үндэслэлээр төрийн албанаас хална.

Иргэн хуулийн этгээдийн мэдээлэл авах эрхийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн шийдвэр гаргах эрх бүхий этгээдийг шүүгч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.





*ШУДАРГА НИЙГМИЙГ
ХАМТДАА ЗУРЬЯ ...*

ТАНЫ **ҮГ** ЧУХАЛ

**ХҮНД
СУРТАЛТАЙ,
АВЛИГАТАЙ
ТӨРИЙН
ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЛ
ТЭВЧЬЕ**